

Жилийн Тайлан 2015



Монгол улсын Засгийн Газарт



байгууллагаас хүргүүлэв

Мерси Кор Монгол
Энх тайвны өргөн чөлөө 30-1, Баянзүрх Дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-461-145
Холбоо барих: Суурин төлөөлөгч Женнифер Бийлман,
И-мэйл: jbielman@mercycorps.org

2015 оны жилийн тайлан

Гарчиг

ТОВЧИЛСОН ҮГС	3
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	4
I. ОРШИЛ.....	4
II. 2015 ОНЫ ГОЛ АМЖИЛТУУД.....	6
III. ТӨСЛИЙН АМЖИЛТУУД ДЭЛГЭРЭНГҮЙ	8
1. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД ӨРСӨЛДӨӨНТ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ (ICOGS).....	8
2. ЗЭЭЛИЙН БАТАЛГАА ГАРГАХ ХӨТӨЛБӨР (ЗБГХ).....	13
3. ГАМШГИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХАД УЛАМЖЛАЛТ БОЛОН ШИНЖЛЭХ УХААНЫ АРГЫГ АШИГЛАХ ТӨСӨЛ-2 (LTS2)	16
4. БҮТЭЭМЖТЭЙ АГРИБИЗНЕСИЙН СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (PACS).....	23
5. ТӨРИЙН БА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН НЬ	24
IV. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯАМ АГЕНТЛАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН НЬ.....	26
V. САНХҮҮГИЙН ТАЙЛАН	28
ХАВСРАЛТ 1: ТББ-УУДЫН ДЭД ТЭТГЭЛЭГТ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ	29

Товчилсон үгс

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БДБ	Бизнесийг дэмжих байгууллага
ЗБГХ	Зээлийн баталгаа гаргах хөтөлбөр
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МААЭУМТ	Мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээллэх тогтолцоо
МУИС	Монгол улсын Их Сургууль
МҮХХ	Монголын үндэсний хөгжлийн хүрээлэн
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУХА	Олон улсын хөгжлийн агентлаг
ТББ	Төрийн бус байгууллага
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААЯ	Хөдөө аж ахуйн яам
ТҮХ	Тендерийн үнэлгээний хороо
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ARREAL	Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо төсөл
ICOGS	Төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг тогтворжуулах төсөл
eS	engageSPARK
LEGS	Мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын үед баримтлах заавар болон стандарт
LTS2	Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах төсөл - 2
PACS	Бүтээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийн сүлжээг дэмжих нь төсөл

2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. Оршил

Мерси Корын Эрхэм Зорилго



Мерси Корын даян дэлхийн эрхэм зорилго нь Өөрчлөлтийн төлөөх алсын хараагаар томъёологдсон, аюулгүй, үр бүтээмжтэй, шударга нийгэм цогцлон байгуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино. Дэлхийн 41 улс оронд 19 сая үр шим хүртэгчдэд хүрч ажилладаг. Мерси Кор тогтвортой, тууштай өөрчлөлтийг дэмжихдээ иргэдийн санаачлага, зах зээлийн харилцаанд тулгуурласан зарчмыг баримталдаг бөгөөд мэдээлэл олж авах, сургалт, санхүүгийн болон бизнесийн үйлчилгээ, зах зээлийг хөгжүүлэх тогтвортой механизмыг бий болгоход нь тусалдаг.

Монгол улсад Мерси Кор нь хөдөө орон нутгийн иргэдэд хувьсан өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицож тэдний нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээг хангахын тулд бүхий л нөөцийг дайчилж дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилго тавин ажиллаж байна. олон нийтийн идэвхтэй оролцоо нь хүртээмжтэй, тогтвортой хөгжил, сайн засаглал, байгаль орчныг хамгаалахад амин чухал тул төр, хувийн хэвшлийн харилцаа холбоо, сайн түншлэл нь бидний ажлын үндэс суурь болдог.

Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

Мерси Кор нь Тэнцвэртэй эдийн засгийн хөгжил, Сайн засаглал, Байгаль орчны хариуцлагатай удирдлага гэсэн өргөн хүрээний, хоорондоо уялдаа холбоотой гурван чиглэлд анхаарлаа хандуулснаар Монгол улсын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж байна. 2015 онд Мерси Кор байгууллага нь Монгол улсад 4 төсөл хэрэгжүүлсэн.

Хүснэгт 1: 2015 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

Төсөл	Хандивлагч байгууллага	Төслийн хугацаа	Хамрагдсан аймгийн тоо
Төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг тогтворжуулах төсөл (ICOGS)	ШХА	2012 оны 5-р сар – 2015 оны 3-р сар	13
Зээлийн баталгаа гаргах хөтөлбөр (ЗБГХ)	АНУ-ын Хөдөө аж ахуйн яам	2004 оноос – одоо үргэлжлэн хэрэгжиж байгаа	15
Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах төсөл -2 (LTS2)	АНУ-ын ОУХА	2015 оны 6 сар – 2016 оны 5 сар	10
Бүтээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийн сүлжээг дэмжих нь төсөл (PACS)	АНУ-ын Хөдөө аж ахуйн яам	2012 оны 9 сар – 2015 оны 9 сар	7

Хөтөлбөр хэрэгжүүлсэн бүс нутаг


2015 онд Мерси Кор Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Дорноговь гэсэн 13 аймгийн түнш байгууллагуудтай хамтран төслүүдээ хэрэгжүүлсэн. Ховд, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймаг дахь бүсийн төвөөрөө дамжуулж түншлэлийн бүтцийг дэмжиж ажиллалаа. 2015 онд Мерси Кор үндэсний хэмжээний 9 байгууллага, орон нутгийн хэмжээний 284 төр ба иргэний нийгмийн байгууллагууд, бизнес эрхлэгчидтэй хамтран 4 төсөл дээр ажилласан.

Бүс нутгийн төв болон салбарууд

Мерси Кор 2015 онд Улаанбаатараас (төв оффис) гадна 5 бүсэд үйл ажиллагаа явуулсан. Үүнд:

- 1) Баян-Өлгий, Увс, **Ховд** (бүс нутгийн төв)
- 2) Говь-Алтай, **Завхан** (бүс нутгийн төв)
- 3) Архангай, Баянхонгор, **Өвөрхангай** (бүс нутгийн төв)
- 4) Говьсүмбэр, Дундговь, **Өмнөговь** (бүс нутгийн төв)
- 5) Сүхбаатар, **Дорноговь** (бүс нутгийн төв)
- 6) **Улаанбаатар** (төв оффис)

Зураг 1. Мерси Корын үйл ажиллагаа явуулдаг бүс нутаг



II. 2015 оны гол амжилтууд

Мерси Кор Монгол байгууллагын ICOGS, LTS2, ЗБГХ төслүүд хөдөө орон нутагт маш их үр дүнтэй хэрэгжсэн. Бид 2015 онд орон нутгийн малчид, эдийн засагт тулгарч буй зудын эрсдэлийг бууруулах, нээлттэй, өрсөлдөөнтэй худалдан авах ажиллагааны тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр амжилттай ажилласан.

Үр шим хүртэгчид

2015 онд Мерси Кор мэдлэг дээшлүүлэх аян, сургалт, олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалт, сайн туршлага түгээх, төрийн мэдээллийг ил тод нээлттэй болгох гэсэн олон төрлийн үйл ажиллагаа явуулсан. Энэ ажлын үр дүнд өнгөрсөн жил 96 364 хүн үр шимийг нь хүртлээ (Хүснэгт 1 үзнэ үү).

Мерси Корын үйл ажиллагаанд дараах хүмүүс оролцож үр шим хүртсэн:

1. Сайн засаглалыг хөгжүүлэх, нээлттэй худалдан авах ажиллагааг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, төрийн мэдээллийг олон нийтэд хүртээх талаар мэдлэг ойлголтоо дээшлүүлсэн **төрийн албан хаагчид**;
2. Төрийн худалдан авах ажиллагаанд оролцож, Мерси Корын дэд тэтгэлгээр чадавхиа бэхжүүлсэн орон нутгийн **иргэний нийгмийн байгууллагууд**;
3. Төрийн худалдан авалтын тендерт оролцсон орон нутгийн **бизнес эрхлэгчид**;
4. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, мал сүрэгт тохиолдох онцгой байдал, мал сүрэгт чиглэсэн үйл ажиллагаа, заавар стандартын талаар мэдлэгээ дээшлүүлж, 69 суманд сургалт зохион байгуулсан орон нутгийн **сургагч багш** нар. Үүнд сум багийн ЗДТГ-ын ажилтнууд, мал эмнэлэг, үржлийн алба, онцгой байдлын газар, цаг уур, байгаль орчны ажилтнууд, ТББ-ууд орно;
5. Сумын эрсдэлийн удирдлагын сургалтанд сууж, LEGS-ын арга зүй, мал сүрэгт чиглэсэн үйл ажиллагаа, онцгой байдлын үед авах арга хэмжээ, мал аж ахуйн хөгжлийн талаар сурч ойлгосон орон нутгийн **малчид, иргэд, төрийн албан хаагч, онцгой байдлын ажилтнууд**;
6. Сайн засаглал, хариуцлага, нээлттэй шударга байдал гэсэн үндсэн зарчмуудын тухай мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж, шийдвэр гаргахад идэвхтэй оролцож, төрийн мэдээллийг ашигласан орон нутгийн **иргэд**;

Хүснэгт 2: Үр шим хүртэгчдийн тоо

Төсөл	Үр шим хүртэгчдийн тоо
ICOGS	94 212
LTS	2 152
Нийт	96 364

ICOGS төсөл амжилттай хэрэгжиж дууслаа

ICOGS төсөл 2012 оны 5 сард эхэлж 2015 оны 3 сард дууссан. Уг төсөл нь Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлагийн (ШХА) 2012 онд эхлүүлсэн Засаглалыг дэмжиж, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн нэг хэсэг байсан юм. ICOGS төсөл 13 аймаг, 26 суманд төрийн худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэхийг зорьж ажилласан. 2,5 жилийн хугацаанд ICOGS төсөл жижиг тэтгэлэг олгох замаар орон нутгийн ХАА алба, 51 ИНБ-дын чадавхийг дээшлүүлэн төрийн ХАА-ны талаархи мэдээллийн хүртээмжийг сайжруулж худалдан авах ажиллагааг өрсөлдөөнтэй болгон, ХАА-н дахь ИНБ-ын оролцоог нэмэгдүүлсэн.

ICOGS төслийн гаргасан гол үр дүн:

- 13 аймгийн 26 суманд 378 төрийн ХАА-ны тендер зохион байгуулагдсан
- 14 төрийн түншлэгч байгууллагатай хамтын ажиллагааны Санамж Бичиг байгуулсан
- 2278 иргэн төрийн ХАА-ны гэрчилгээжүүлэх сургалтанд сууж, 969 хүн шалгалтанд тэнцэж, гэрчилгээ авсан.

“Гамшгийн аюулыг тооцё, эртлэн төлөвлөе, эрсдэлгүй давъя” сэдэвт сургалт

LTS2 төслийн баг “Гамшгийн аюулыг тооцё, эртлэн төлөвлөе, эрсдэлгүй давъя” сэдэвт сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Уг сургалтыг орон нутгийн сургагч багш нарт зохион байгуулж, 164 аймаг сумын сургагч багш нарыг бэлдсэн. Эдгээр 164 сургагч багш нь зорилтот 69 суманд 1940 хүнийг хамарсан сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтанд оролцогчид LEGS-ын стандарт, аргачлал, мал сүрэгт чиглэсэн үйл ажиллагаа, онцгой байдлыг үед авах арга хэмжээ, амьжиргааг хамгаалах тухай мэдлэг эзэмшсэн. Сургалтын үеэр нийт 35 сумын гамшгийн төлөвлөгөөнд хэсэгчилсэн өөрчлөлт орууллаа. Тухайн орон нутгийн онцлогт тохирсон гамшгийг тодорхойлж, түүнд тохирсон төлөвлөгөөний загварыг боловсруулсан.

“Орон нутгийн худалдан авах ажиллагааны сайн туршлагууд” номыг хэвлэж түгээлээ

ICOGS-ын хүрээнд “Орон нутгийн худалдан авах ажиллагааны сайн туршлагууд” хэмээх номыг 2015 онд гаргалаа. Тус номыг ICOGS төслийн Монголд хэрэгжсэн 2,5 жилийн туршлага дээр үндэслэж бичсэн бөгөөд номонд: 1) “сайн туршлагын” үндсэн ойлголт 2) төрийн худалдан авах ажиллагааны журам 3) төрийн худалдан авах ажиллагаан дахь авилгалын эрсдэл 4) төрийн худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын үүрэг хуваарь 5) орон нутгийн ХАА алба, ИНБ, хэвлэл мэдээллийн байгууллага гэх мэт түншүүдээс цуглуулсан сайн туршлагууд орсон.

1000 гаруй ном хэвлэж Сангийн яам, Худалдан авах ажиллагааны газар, их дээд сургуулиуд, ИТХ, аймгийн засаг захиргаа, орон нутгийн ХАА алба, ИНБ-ын сүлжээний гишүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд зэрэг үндэсний болон орон нутгийн түнш байгууллагууддаа түгээлээ.. Мерси Корын вэбсайтаас дараах хаягаар энэ номыг татаж авч болно: <http://mercy Corps.org.mn/beta/index.php/en/projects/completed-projects/305-ICOGS>

Онлайн технологийг ашиглаж хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлсэн

2015 онд Мерси Кор хөтөлбөрийнхөө хүрээнд мэдээллийн олон төрлийн технологи ашиглаж чадсан. Мерси Кор Blackboard, ooVoo, Skype программыг ашиглан алс холын аймгуудтай холбогдож ажлаа явуулдаг. Онлайн уулзалт сургалт зохион байгуулах нь их түгээмэл болж байна.

2015 онд Мерси Кор байгууллагын бодлого, санхүүгийн дүрэм журам, малчдын зээлийн судалгаа, цаг агаарын мэдээ, цахим худалдан авалт гэсэн олон сэдвээр 13 аймгийн 670 хүнийг хамарсан 50 онлайн уулзалт зохион байгууллаа. . Мерси Кор Skype программ ашиглан 2 долоо хоногт нэг удаа аймгийн ажилтнуудтай ажлын уулзалт тогтмол зохион байгуулдаг.

Онлайн технологи нь Мерси Корт мөнгө хэмнэх боломж олгодог. 2015 онд онлайн технологийн ачаар 101 800 ам доллар хэмнэж чадсан гэсэн судалгаа байдаг. Онлайн технологи нь хөтөлбөрийн түнш, үр шим хүртэгсэдтэй илүү олон удаа уулзах боломж олгож, хөтөлбөрийн үр нөлөөг эрс дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулсан билээ.

III. Төслийн амжилтууд дэлгэрэнгүй

1. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД ӨРСӨЛДӨӨНТ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ (ICOGS)

Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлаг

2012 оны 5 сар – 2015 оны 3 сар


Төслийн зорилго

13 аймаг, 26 суманд төрийн худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Төслийн зорилтууд

- Бизнес эрхлэгч, иргэд төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийг цаг тухайд нь авах мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Төрийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах орон нутгийн төрийн болон худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх
- Төрийн худалдан авах ажиллагааны явц болон гэрээний гүйцэтгэлд иргэд, олон нийт хөндлөнгийн хяналт тавих чадавхийг сайжруулах

Зураг 2. ICOGS төслийн аймгууд



ICOGS төсөл 2012 оны 5 сард эхэлж 2015 оны 3 сард дууссан бөгөөд энэхүү төсөл нь Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлагийн (ШХА) 2012 онд эхлүүлсэн Засаглалыг дэмжиж, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн нэг хэсэг юм. ICOGS төсөл нь Монгол улсын Засгийн газрын төрийн худалдан авах ажиллагааг бэхжүүлэх стратегийг орон нутагт дэмжиж, 13 аймгийн худалдан авах ажиллагааны тогтолцоог бэхжүүлсэн. Уг төсөл орон нутгийн төр, худалдан авах ажиллагааны алба, иргэний нийгмийн байгууллагуудын нээлттэй худалдан авах ажиллагааны дүрэм журмыг мөрдөх чадавхийг бэхжүүлсэн. Эцэст нь ICOGS төсөл ИНБ-дад ХАА-нд идэвхтэй,

хариуцлагатай оролцох тогтолцоо механизмыг бүрдүүлж, орон нутгийн тендерийн мэдээллийг иргэд, хувийн хэвшлийнхэнд хүртэх боломжийг нь сайжруулж өгсөн.

Орон нутгийн төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн нь ICOGS-ын амжилтын чухал хүчин зүйл байсан. Энэ төсөл нь чадавхи бэхжүүлэх, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, хэвлэл мэдээллийн дэмжлэг авах, эрх зүйн нөлөөллийн ажил явуулах, иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх замаар орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлсэн Төслийн зорилтот бүх аймгийн түнш байгууллагууд төсөл боловсруулах, хэрэгжүүлэх гээд бүхий л үе шатанд Мерси Кортой хамтран ажилласан.

ICOGS-ын жижиг тэтгэлгийн үр дүнд ИНБ-ууд ХАА-нд оролцох, хянах мэдлэг, туршлага, ур чадвараа сайжруулж эхэлсэн. ИНБ-ийн гишүүд орон нутгийн төрийн албан хаагчид, хэвлэл мэдээллийн байгууллага, гэрээт бизнес зэрэг талуудтай харилцах; мониторингийн бүлэг байгуулах, дэмжих; байгууллага, аймаг хоорондын хамтын ажиллагааны сүлжээ байгуулах зэрэг олон чиглэлээр туршлага хуримтлуулж чадсан:

ICOGS төсөл илүү үр өгөөжтэй, бүтээмжтэй ХАА-ны арга барилыг нэвтрүүлсэн. Төслийн хүрээнд аймаг суманд бодит үр нөлөө гарч, төрийн авилгалын талаархи сөрөг хандлагыг арилгаж чадсан нь ялангуяа төрийн тендертэй холбоотой; тулгарч буй асуудалд анхаарал хандуулах арга барилаас төр, иргэний нийгэм хамтран засаглалыг сайжруулах арга барил руу шилжсэн.

Төслийн үр дүн 2015 онд

Хамтран ажиллах санамж бичгийн биелэлтийг дүгнэж шинэчлэн байгуулав

Мерси Кор байгууллага Худалдан авах ажиллагааны газар, 13 аймгийн удирдлагатай хамтын ажиллагааны Санамж Бичиг байгуулж, төсөл хэрэгжүүлэх, үнэлэхэд талуудын үүрэг хариуцлагыг



Фото зураг 1: Санамж бичгийн биелэлтийг дүгнэж байгаа нь, Дорноговь аймаг

нь тодорхойлж өгсөн. Энэхүү түншлэлийн хүрээнд талууд нээлттэй аргаар зорилтот бүлгээ сонгож, төсөл хэрэгжүүлэх, төлөвлөх, хөрөнгө босгоход ИНБ-ын дэмжлэг авсан.

Хамтран ажилласны үр дүнд олон нийтэд ашиглах боломжтой ХАА-ны мэдээллийн сан, мэдээлэл түгээх тогтолцоо байгуулагдаж, чадавхи бэхжүүлэх сургалтанд орон нутгийн нөөц бололцоог илүү ихээр ашиглаж, орон нутгийн төсөвт ИНБ-аар ХАА-г хянах ажилд зориулж тодорхой хөрөнгө мөнгө тусгасан. Төрийн байгууллагуудтай хамтран ICOGS төсөл зорилтот 39 сумаа сонгох тодорхой шалгуур

боловсруулсан билээ.

2015 оны 1-3 сард ICOGS төсөл түншүүдтэйгээ хамтран зорилтот аймгуудад Санамж Бичгийн биелэлтийг дүгнэж, тулгарч байгаа саад бэрхшээл, гаргасан амжилтаа хэлэлцэх зорилготой уулзалт зохион байгууллаа. Уулзалтанд Мерси Кор, аймгийн ЗДТГ, орон нутгийн худалдан авах ажиллагааны алба, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөгчид бүгд идэвхтэй оролцсон бөгөөд ICOGS төсөл орон нутгийн төр захиргаатай хамтран 2015 оны байдлаар төлөвлөгөөний 94,8%-ийг биелүүлж чадсан гэсэн дүгнэлт гарсан.

Хамтын ажиллагааны үр дүн

- Чадавхи бэхжүүлэх сургалтын хэрэгцээг хангахад ICOGS болон орон нутгийн байгууллагуудын нөөц бололцоог дайчилсан;
- ИНБ-уудыг ТҮХ болон ХАА-ны мониторингийн ажилд идэвхтэй оролцуулахад ажлын удирдамж боловсруулж, санхүүжилт олгосон;
- Илүү хүртээмжтэй ХАА-ны мэдээллийн сан, мэдээлэл түгээх тогтолцоо байгуулсан;
- Төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлсэн
- Орон нутгийн төр засаг ICOGS төслийн сайн туршлагаудыг тогтвортой нэвтрүүлж үргэлжлүүлэх амлалт өгсөн

Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт

2011 онд шинээр батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулинд ТҮХ-ийн гишүүн бүр ХАА-ны гэрчилгээтэй байх ёстой гэж заасан байгаа. Тиймээс ХАА-ны мэргэшүүлэх сургалтын эрэлт хэрэгцээ үүссэн.

2015 онд Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтыг Баянхонгор, Дорноговь аймагт зохион байгуулсан ба сургалтанд нийт 85 хүн хамрагдаж, үүнээс 45% (38) нь эмэгтэйчүүд оролцсон. Нийт оролцогчдын 35 (41%) нь сургалтанд амжилттай оролцож гэрчилгээгээ гардан авсан. Үүнээс 17 нь эмэгтэйчүүд байсан.

А3 сургалт нь ICOGS төслийн үндсэн үйл ажиллагааны нэг нь байсан бөгөөд төслийн бүх үе шатанд хэрэгжсэн. 2012-2015 оны хооронд Худалдан авах ажиллагааны газар, Сангийн яамны зөвшөөрөлтэй боловсролын байгууллагуудтай хамтран ICOGS төсөл 13 аймагт 28-н А3 сургалт зохион байгуулжээ. Орон нутгийн засаг захиргаа



Фото зураг 2: ХАА-ны сургалт, Улаанбаатар

бүх сургалтын зардлын 50%-ийг гаргасан. Нийт 2278 хүн 28 сургалтанд оролцсон бөгөөд оролцогчдын 760 нь (33,4%) эмэгтэйчүүд байсан. Сургалтанд суусан бүх оролцогчдын 969 нь (42,5%) шалгалтаа амжилттай өгч гэрчилгээ авсан ба үүний. 481 нь (49,6%) эмэгтэйчүүд байсан. Сургалтанд орон нутгийн ХАА алба, ИТХ, ЗДТГ, ИНБ, иргэд зэрэг олон байгууллагын төлөөлөгчид суусан. Гэрчилгээ авсан хүмүүс 13 аймгийн 378 ТҮХ-д ажилласан. ТҮХ бүрт нэгээс доошгүй иргэний нийгмийн төлөөлөгч ажиллаж байсан нь иргэд мэргэшүүлэх сургалтанд идэвхтэй оролцож, шалгалтаа амжилттай өгч чадаж байгаагийн илэрхийлэл юм.

Сургалтанд оролцогчдын дунд явуулсан судалгааны үр дүнд гэрчилгээ авсан хүмүүсийн 90% нь ТҮХ-д орох эсвэл гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан гэдгийг тогтоожээ.

Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудад зориулсан сургалт, хэлэлцүүлэг

2015 онд ICOGS төслийн хүрээнд төрийн албан хаагч, ТҮХ-ийн гишүүд, хэвлэл мэдээллийн ажилтнууд, ИНБ гээд нийт 745 хүнийг хамарсан 26 танхимын сургалт боллоо. Нийт 34 уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулагдаж 858 хүн оролцсон байна.

Хүснэгт 3: 2015 оны сургалт, уулзалтын тоо

Сар	Сургалт		Уулзалт	
	Арга хэмжээ	Оролцогчид	Арга хэмжээ	Оролцогчид
1 сар	11	279	15	399
2 сар	4	119	7	117
3 сар	11	347	12	342
Нийт	26	745	34	858

2012-2015 оны хооронд ICOGS төслийн хүрээнд төрийн албан хаагч, ТҮХ-ийн гишүүд, хэвлэл мэдээллийн ажилтнууд, ИНБ-уудад зориулсан 202 сургалт зохион байгуулагдаж, 5967 хүн оролцлоо. Сургалтууд дараах сэдвээр явагдсан:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн материал бэлдэх;
- Төсвийн нээлттэй байдал, төсвийг хянах арга зүй;
- Худалдан авах ажиллагааг ИНБ-аар хянуулах;
- Төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх;
- Институцийн хөгжил, удирдлага;
- Онлайн сургалтууд;

“Орон нутгийн худалдан авах ажиллагааны сайн туршлагууд” ном

ICOGS-ын хүрээнд “Орон нутгийн худалдан авах ажиллагааны сайн туршлагууд” хэмээх номыг 2015 онд гаргалаа. Тус номыг ICOGS төслийн Монголд хэрэгжсэн 2,5 жилийн туршлага дээр үндэслэж бичсэн. Номонд дараах сэдвүүд орсон: 1) “сайн туршлагын” үндсэн ойлголт 2) төрийн худалдан авах ажиллагааны журам 3) төрийн худалдан авах ажиллагаан дахь авилгалын эрсдэл 4) төрийн худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын үүрэг хариуцлага 5) орон нутгийн ХАА алба, ИНБ, хэвлэл мэдээллийн байгууллага гэх мэт түншүүдээс цуглуулсан сайн туршлагууд.



Фото зураг 3: “Орон нутгийн худалдан авах ажиллагааны сайн туршлагууд” ном

1000 гаруй ширхэг ном хэвлэгдэж үндэсний болон орон нутгийн түнш байгууллагуудад түгээгдсэн. Үүнд:

Сангийн яам, Худалдан авах ажиллагааны газар, их дээд сургуулиуд, ИТХ, аймгийн засаг захиргаа, орон нутгийн ХАА алба, ИНБ-ын сүлжээний гишүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд. Мерси Корын вэбсайтаас дараах хаягаар энэ номыг татаж авч болно: <http://mercycorps.org.mn/beta/index.php/en/projects/completed-projects/305-ICOGS>

ИНБ-ын дэд тэтгэлэг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2013, 2014 онд ICOGS төсөл дэд тэтгэлгийг хоёр үе шаттай зарласны үр дүнд 13 аймгаас 119 төслийн санал ирж, 61 орон нутгийн ИНБ шалгарсан. ICOGS төслийн бүх дэд тэтгэлгийн жагсаалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 4: Дэд тэтгэлэг

	Дэд тэтгэлгийн тоо	Үйл ажиллагааны тоо	Үр шим хүртэгсдийн тоо	Эмэгтэйчүүдийн тоо	Дэд тэтгэлгийн хэмжээ, сая төгрөг
ICOGS	61	344	138 617	70 742	147,1

Дэд тэтгэлгийн төслүүд нь чадавхи бэхжүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог идэвхжүүлэх аргаар төрийн худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан билээ. Дэд тэтгэлгийн төслүүд дараахь зорилтонд хүрэхийн төлөө ажилласан:

- ХАА-ны сургалт зохион байгуулах, тендерийн материалыг боловсруулах, тайлагнах, архивлах зэрэг төрийн худалдан авах үйл ажиллагаанд оролцогч талуудын ур чадварыг бэхжүүлэх;
- Орон нутгийн төр, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран төрийн ХАА-ны мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах;
- Төрийн худалдан авах ажиллагааны төлөвлөлтөнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Төрийн ХАА болон тендерийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавихад ИНБ-ын оролцоог дээшлүүлэх;
- 3 талт түншлэлийн зөвлөлийг бэхжүүлэх, орон нутгийн ИТХ-ээр удирдуулсан Иргэний танхимд 3 талт түншлэлийн ажиллагааг нэвтрүүлж хэвшүүлэх;
- Орон нутгийн ИТХ-ээс удирдан байгуулсан Иргэдийн Хяналтын Зөвлөлийг Түншлэлийн зөвлөлтэй үйл ажиллагааны хувьд уялдуулан өргөжүүлэх, бэхжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ХАА-нд оролцуулснаар ХАА-ны хүртээмжтэй орчинг сайжруулахад хувь нэмрээ оруулах;



Фото зураг 4: Нээлтэй тендэрээр Увс аймгийн 1-р сургуулийг засварласан

2015 онд Мерси Короос дэд тэтгэлэг авсан сүүлчийн 19 байгууллага төслөө амжилттай хэрэгжүүлж дуусгаад эцсийн тайлангаа 3 сард боловсруулж илгээсэн.

2. ЗЭЭЛИЙН БАТАЛГАА ГАРГАХ ХӨТӨЛБӨР (ЗБГХ)

АНУ-ын Хөдөө аж ахуйн яам (2004 оноос)


Төслийн зорилго

Хөдөө орон нутгийн бизнес эрхлэгчдэд арилжааны банкуудаас зээл авахад нь зээлийн баталгаа гарган дэмжлэг үзүүлэх

Төслийн зорилтууд

- Бизнесийн санаагаа хэрэгжүүлэх болон бизнесээ өргөжүүлэх зорилготой орон нутгийн иргэдийн санхүүгийн чадавхийг нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- Орон нутгийн бизнес эрхлэгчид болон санхүүгийн байгууллагуудын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх, бизнес эрхлэгчдийн зээл, санхүүгийн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлж чадваржуулах
- Орон нутгийн бизнес эрхлэгчдэд зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг илүү тааламжтай болгохын тулд санхүүгийн байгууллагуудын хоорондох шударга өрсөлдөөнийг дэмжих, тэдний санал болгож буй үйлчилгээний нөхцөлд эерэгээр нөлөөлөх.

Зураг 4. ЗБГ хөтөлбөрийн аймгууд



Мерси Корын ЗБГХ-ийг анх 2004 онд АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны төслийн хөрөнгөөр санхүүжүүлж байсан. 2010 онд ЗБГХ тусдаа төсөл болж шинэ бизнес эхлэх, өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор бичил болон жижиг, дунд бизнесийн зээлийн баталгааг үргэлжлүүлэн гаргасан юм. 2012 оны 9 сард төслийн шинэ стратегийг баталж, хэрэгжиж эхэлтэл шинээр зээлийн баталгаа гаргахыг зогсоосон. 2015 онд ЗБГХ өмнөх онд гаргасан зээлүүдийнхээ эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллалаа. Мерси Кор ХАС банк, ХААН банк, Төрийн банк гэсэн санхүүгийн гурван банкттай хамтран ажилласан. Мерси Кор зээлийн баталгаагаа гэрээт 20 бизнесийг дэмжих байгууллагын (БДБ) сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлдэг байсан бөгөөд БДБ-ууд зээлийн үнэлгээ, мониторинг хийж, бизнесээ хөгжүүлэхэд зөвлөгөө өгч, зээлийн буцаан төлөлтөнд нь хяналт тавьж ажиллаж байсан.

Төслийн үр дүн 2004-2015

ЗБГХ 2004 оноос хойш хэрэгжих хугацаанд 13,3 тэрбум төгрөгийн нийт 3423 зээлд 4,9 тэрбум төгрөг буюу 36,8%-ийн нэмэлт барьцааг гаргасан байна. Эдгээр зээлүүд давхардсан тоогоор нийт 2706 хүнд олгогдсон; 82% нь шинээр бизнес эхлүүлэх, 18% нь хуучин бизнесээ өргөжүүлэхэд зориулсан. Нийт зээлийн 58,2% буюу 1993 зээлийг хувь хүмүүст олгогдсон бол 12,1% хоршоодод, 9,9% нь малчдын бүлэгт, 8,2% нь нөхөрлөлд, 7,1% нь ХХК-уудад, үлдсэн 4,5% нь патент эзэмшигч, ТББ-уудад олгогдсон байна.

Зээлийн багц

2015 оны 1 сарын байдлаар харилцагч хоёр банкинд нийт 33 750 000 төгрөгийн 4 зээл үлдэж, Мерси Корын батлан даалтын хэмжээ нь 12 622 500 төгрөг байсан. 2015 онд хоёр зээл нь хугацаандаа эргэн төлөгдөж, Дундговь, Өвөрхангай дахь хоёр зээл нь төлөгдөж чадалгүй найдваргүй зээлийн тоонд орсон. Мерси Кор банкуудтай хамтран ажилласны үр дүнд өөрийн төлөх батлан даалтын хувиа төлж асуудлыг шийдэж чаджээ.

“Д. Өөлд” мужаан цех

Ховд аймгийн Жаргалант сумын иргэн Д. Өөлд 1990 онд цомхотголд өртөн ажилгүй болж таксины үйлчилгээ эрхэлдэг байжээ. Өөлд мужаан мэргэжилтэй, барилгын салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрбээр захиалгаар ганц нэг гэрийн мод, модон эдлэл хийж, бизнесээ өргөжүүлэхээр зээл хайсан боловч зээлийн хүү өндөр, барьцаа хүрэлцээгүйн шалтгаанаас хүссэн зээлээ авч чаддаггүй байлаа. Өөлд Мерси Корын хэрэгжүүлсэн Зээлийн Баталгаа Гаргах Хөтөлбөрт (ЗБГХ) хамрагдаж, 2015 оны 7 сард зээлээ бүрэн төлж дууссан сүүлчийн үйлчлүүлэгчдийн нэг нь юм.



Өөлд 2010 онд Мерси Корын RASP хөтөлбөрийн бизнесийн сургалтанд сууж, 2012 онд 15 сая төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай, сарын 1,16% хүүтэй авчээ. ЗБГХ зээлийн 40% барьцаа гаргаж өгч. Өөлд гаргасан амжилтандаа сэтгэл хангалуун “Би Мерси Кор болон ЗБГХ хөтөлбөрт их талархаж явдаг. Би үйлдвэртээ нэмж ажилчин хөлсөлж, миний орлого бараг хоёр дахин өсч, 14,1 сая төгрөг болсон. Миний үйлдвэрлэлийн нэр төрөл нэмэгдэж, чанар нь сайжирч, би одоо орон сууц барьж эхэлсэн. Би Мерси Корын дэмжлэгтэй л ийм амжилтанд хүрсэн гэж боддог” гэж ярьжээ.

“Хүртгээмжтэй санхүүгийн үйлчилгээ” төсөл

ЗБГХ эхэлсэнээс хойш Монгол улсын эдийн засагт томоохон өөрчлөлтүүд гарчээ. Монголын эдийн засаг өргөжиж төрөлжсөн. Харилцаа холбоо сайжирч, зах зээлийн мэдээ мэдээлэл авах боломжууд эрс нэмэгдсэн. Банкууд олон төрлийн зээлийн бүтээгдэхүүн гаргаж, хүү нь буурсан. Монгол улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо хамтран 2012 оны 11 сард Зээлийн Батлан Даалтын Сан (ЗБДС) байгуулж, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргадаг болсон.

2015 онд Мерси Кор ЗБГХ-ийн үр нөлөөний үнэлгээ явуулж, санхүүгийн зах зээлийн судалгаа хийлээ. Судалганы үр дүнд Мерси Кор ЗБДС-тай хамтран Хүргэмжтэй Санхүүгийн Үйлчилгээ төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон. Уг төсөл нь ЗБГХ-ын үргэлжлэл төсөл гэж бид харж байгаа. Төслийн гол зорилго нь ЗБДС-ын үйлчилгээг арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагаар (ББСБ) дамжуулан аймаг сумдын ЖДҮ-д хүргэхэд оршино. Туршилтын үйл ажиллагааг 3 аймагт эхлүүлж, амжилт гарвал Даван Туулах, Дасан Зохицох Орон Нутгийн Иргэд төслийн хүрээнд 16 аймагт үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Туршилтын үйл ажиллагаа нь 6-9 сар үргэлжилнэ.

Одоогийн байдлаар Мерси Кор төслийн стратеги, ажлын төлөвлөгөө боловсруулж байна. ЗБДС-тэй хамтын ажиллагааны Санамж Бичиг байгуулж, талуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой зааж өгнө.

3. ГАМШГИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХАД УЛАМЖЛАЛТ БОЛОН ШИНЖЛЭХ УХААНЫ АРГЫГ АШИГЛАХ ТӨСӨЛ-2 (LTS2)

АНУ-ын ОУХА-ын харьяа Гамшигт нэрвэгдсэн гадаад орнуудад тусламж үзүүлэх газар
2015 оны 6 сар – 2016 оны 5 сар


Төслийн зорилго:

Шаардагдах цаг агаарын мэдээллийг түгээж орон нутагт гамшгийн төлөвлөлт болон эрсдлийг бууруулах чадавхийг сайжруулснаар малчид болон хөдөөгийн эдийн засагт тохиох зудын эрсдлийг бууруулах

Төслийн зорилт:

1. Орон нутагт сургалтын хөтөлбөрийг албан ёсны бүтцэд оруулах (институтчилах)
2. Мессежед суурилсан үндэсний мэдээллийн тогтолцоог бий болгох

Зураг 5. LTS2 төслийн аймгууд



Гамшгийн Эрсдлийг Бууруулахад Уламжлалт Болон Шинжлэх Ухааны Аргыг Ашиглах Төсөл-2 (LTS2) 2015 оны 5 сард эхэлсэн. Мерси Корп LTS2 төслийг Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ), Мал Аж Ахуйн Эрсдлийг Урьдчилан Мэдээллэх Тогтолцоо (МАНЭУМТ), Монголын Үндэсний Хөгжлийн Хүрээлэн (МҮХХ) болон Кейо Их Сургуультай хамтран хэрэгжүүлж байна.

LTS2 төсөл нь малчдын зудтай тэмцэх чадварыг сайжруулах, тогтвортой бэлчээрийн стратеги боловсруулахад нь зориулж мессеж дээр суурилсан цаг агаарын мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлэх замаар малчдыг дэмжиж, байгалийн гамшгийг даван туулах орон нутгийн бүтцийг бэхжүүлнэ.

2015 оны төслийн үр дүн

Эрсдлийн удирдлагын бодлого ба үйл ажиллагаа

Дэд салбар 1: Олон нийтийн мэдлэг, ойлголт/оролцоог сайжруулах

Үйл ажиллагаа 1.1 Мессеж үйлчилгээний систем

LTS2 төслийн баг engageSPARK (eS) программ дээр суурилсан мессеж түгээх систем дээр ажиллаж эхэлсэн. Кейо Их сургуулийн эрдэмтэд Монголд 2015 оны 7 сард ирж Мерси Кортой уулзаж, ажлын төлөвлөгөөгөө боловсруулсан. Мессеж үйлчилгээний системийн суурь нь eS программ юм. eS программ нь тогтмол хуваарийн дагуу мессежийг автоматаар сервер дээр байршуулна. Мэдээлэл хүссэн мессеж явуулсан хэрэглэгч рүү eS программ автоматаар цаг агаар, бэлчээрийн мэдээ илгээдэг болохыг зорьж байгаа. eS программ мессежээ латин, кирилл үсгээр аль ч үүрэн холбооны операторын хэрэглэгч рүү явуулах боломжтой.

EngageSPARK нь (<https://www.engagespark.com/>) Энэтхэг улсад байрладаг, Мерси Кортой хамтран ажилладаг, хөдөлгөөнт мессеж үйлчилгээний программ зохиодог компани юм. eS программ ашигласнаар LTS2 төсөл мессеж илгээх, турших, хэрэглэгчдийн хэрэгцээнээс хамаарч үйлчилгээндээ өөрчлөлт зохицуулалт хийх гээд олон төрлийн үйл ажиллагаа явуулах боломжтой. Үүнээс гадна мессеж түгээх хамгийн зохистой шийдэл дээр орон нутгийн хөдөлгөөнт холбооны оператор, хөдөлгөөнт холбооны зохицуулах газартай хамтран ажиллах болно.

Мерси Кор мессежийн системээ өөрийн хяналтан доор ажиллуулна. Системээ боловсруулж дууссаны дараа аль байгууллага энэ ажлыг ирээдүйд хариуцах, хэр их нөөц хөрөнгө шаардлагатайг тодорхойлж шийднэ.

Үйл ажиллагаа 1.2 Мессежийн системийн хэрэгжилт

Мерси Кор, МҮХХ, Кейо Их сургууль, Техасын Их сургууль, МAAЭУМТ хамтран мессеж бичих, түгээхэд хэрэгцээтэй мэдээллийн урсгалаа тодорхойлж чадсан. Мерси Кор МAAЭУМТ багийн тусламжтай зорилтот суман дахь 173 хяналтын цэгтэй газрын зураг бүтээжээ. Хяналтын цэг, нутгийн өвөрмөц нэрийг агуулсан зургийг Кейогийн Их сургуульд илгээж, тухайн бүс нутгийн онцлогтой мессеж програмчлахад дэмжлэг үзүүлжээ.

2015 оны 9 сараас хойш Кейогийн Их сургууль туршилтын журмаар 10 суманд зориулсан автомат мессеж үйлчилгээ нэвтрүүлжээ. Мерси Кор төслийн 10 аймаг тус бүрээс нэг сум сонгож орон нутгийн цаг агаарын мэдээ түгээх үйлчилгээг туршсан. Сонгосон 10 сумаас найман суманд автомат мессежийн систем амжилттай туршигдсан¹. Одоо Даваа гараг бүр найман сумын цаг агаар, бэлчээрийн мэдээтэй мессежүүд Кейогийн сервер дээр хадгалагдаж, хүссэн хэрэглэгч бүр энэ мэдээллийг авах боломжтой болсон.

Одоогийн байдлаар LTS2 төсөл орон нутгийн мэдээлэл түгээх асуудлуудыг шийдэх, үлдсэн 60 суманд мессеж үйлчилгээгээ нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байна. Мерси Кор монгол программистуудыг сургаж, зорилтот сум бүрт зориулж автомат мессежийн систем боловсруулах төлөвлөгөөтэй байгаа. МУИС, МAAЭУМТ, Мерси Короос хамгийн доод нь 4 программист сонгож сургалтанд хамруулна. Сонгогдсон программистууд цаг агаарын мэдээтэй мессеж кодлох, 69 суманд мессежийн систем хянах, ажиллуулах аргыг суралцана.

¹ Эрдэнэцагаан (СҮ), Адаацаг (ДУ), Өгийнуур (АР), Зүүнбаян-Улаан (ӨВ), Сонгино (ЗА), Тонхил (ГА), Цэнгэл (БӨ), Давст (Увс).

Үйл ажиллагаа 1.3 Олон нийтийн оролцоо

Мессеж илгээж цаг агаарын мэдээ авдаг систем нь хамгийн оновчтой арга гэсэн дүгнэлтэнд LTS2 төслийн баг хүрлээ. Хэрэглэгчид заавал сургалтанд хамрагдаж энэ үйлчилгээг ашиглаж сурдаг нь энэ системийн сул тал нь юм. Харин гар утасны сүлжээ тасардаг нөхцөлд малчид өөрсдийн боломжтой үед мэдээлэл авах нөхцөл бүрдэж байгаа нь энэ системийн давуу тал болох юм.

Сургагч багшийн сургалтын явцад цаг агаар, бэлчээрийн мэдээг мессежээр хүлээн авах үйлчилгээг анх танилцуулсан. Сургалтын гурван бүлгээс 90% нь мессеж хүлээн авч, уншиж чадсан. Утасны сүлжээ тасрах, холбогдох боломжгүй болох нь гол асуудал болж байлаа. Хэрэглэгчид мессеж авах үед бүгд сүлжээ сайтай газар байх ёстой. Тиймээс утасны сүлжээтэй газар хүссэн үед мессеж авах үйлчилгээг хөгжүүлэх нь нэн чухал болж байна. Зарим ахмад хүмүүс гар утсаа сайн ашиглаж чадахгүй байгаа нь харагдаж байсан. Хүссэн үедээ цаг агаарын мэдээ хүлээн авах боломжтой энэхүү системд бүх оролцогчид маш их таатай хандсан.

67 сумын сургалтаар сургагч багш нар мессеж илгээх, цаг агаарын мэдээ хүлээн авахыг оролцогчдод зааж өгсөн. Шинэ хэрэглэгч бүр сервер рүү мессеж илгээж бүртгүүлсэн. Бүртгүүлсэний дараа дахин шинэ мессеж явуулж хүссэн нутгийн цаг агаарын мэдээг хүлээн авч байсан.

Сургалтанд оролцсон нийт 1940 хүнээс 795 хүн серверт хандаж, 604 (80.5%) хүн бүртгүүлсэн. 1319 (68%) хүн серверт холбогдож чадаагүй. Үүнээс 197 хүн хүчтэй шуурганы улмаас серверт холбогдож чадаагүй. 247 хүн серверээс хариу мессеж аваагүй. 229 хүн гар утаснаасаа мессежээ зөв бичиж чадаагүй. Үлдсэн 663 хүн гар утасгүй, утас нь мессеж бичих боломжгүй эсвэл утас нь цэнэггүй байсан шалтгаанаар серверт хандаж чадсангүй.



Фото зураг 5: Сургагч багш нар мессежийн туршилт хийж байна. Завхан аймаг.

eS систем 711 бүртгүүлэх хүсэлт хүлээж авсан. 672 хүний бүртгэлийг баталгаажуулсан мессеж eS-ээс илгээсэн. Хэд хэдэн мессеж буруу бичигдсэн тул серверт бүртгээгүй. Мөн сүлжээ тасрах гэсэн нөхцөл байдал хүлээн авах талд гарч байсан.

Бүртгүүлсэн хэрэглэгч бүр нэгээс доошгүй цаг агаарын мэдээ хүссэн мессежийг eS систем рүү явуулсан. Хариуд нь eS систем 458 цаг агаарын мэдээ илгээсэн. Энэхүү туршилтаар систем болон хэрэглэгчдэд тулгардаг түгээмэл асуудлуудыг илрүүлж, хэрэглэгчдэд сургалт явуулах нь зүйтэй юм байна гэсэн дүгнэлт гарсан. Бүх оролцогчид системд нэвтэрч чадаагүй ч энэхүү шинэ мессежийн системийг сайшаасан. Учир нь:

- Мэдээллийг хэрэглэгч хүссэн үедээ хүлээн авах боломжтой
- Ямар ч маркийн утас, операторын хэрэглэгч мэдээллийг хүлээн авч болдог
- Цаашдаа мессежийг кирилл үсгээр авах боломжтой

Дэд салбар 2: Чадавхи бэхжүүлэх ба сургалт

Үйл ажиллагаа 2.1 Түншлэгч байгууллагуудын оролцоо, төлөвлөлт

2015 оны 6 сард LTS2 төслийн баг ОБЕГ-тай хамтран сургалтын хөтөлбөр боловсруулж, ажлын төлөвлөгөө гаргасан. ОБЕГ жилд 4-6 аймагт хоёр төрлийн сургалт зохион байгуулдаг – мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалт, олон нийтэд зориулсан гамшгаас хамгаалах сургалт. Зудын эрсдлийг бууруулах ажил бол илүү өргөн хүрээтэй ойлголт гэж LTS2 төслийн сургалтаар үздэг. Хамтын сургалтаар ОБЕГ хамрах хүрээгээ тэлж, хувийн хэвшлийн төлөөлөгчдийг илүү оролцуулах боломж нээгдэнэ.

6 сараас Мерси Корп LTS2 төслийн зудын эрсдлийг бууруулах сургалтын хөтөлбөрийг хамтран боловсруулахад, сургалтанд оролцох орон нутгийн сургагч нарыг хамтран сонгох саналаа ОБЕГ, УЦУОШГ-д тавьсан. УЦУОШГ оролцохоос татгалзсан бөгөөд 2015 оны 8 сараас Мерси Корп, ОБЕГ, МҮХХ хамтарч сургагч багшийн болон сумын сургалтын хөтөлбөр, хуваарь, материалуудыг бэлдсэн. Мерси Корп, ОБЕГ, орон нутгийн удирдлагууд нийлж сургалтанд оролцох сургагч багш нарыг сонгосон.

2015 оны 10-11 сард аймгуудын орон нутгийн Онцгой байдлын албууд сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, зарим суманд гамшгийн төлөвлөгөө сайжруулахад туслалцаа үзүүлсэн.

Үйл ажиллагаа 2.2 Сургалтын хөтөлбөр

ОБЕГ-тай хамтран LTS2 төслийн баг “Гамшгийн аюулыг тооцъё, эртлэн төлөвлө, эрсдэлгүй давъя” сэдэвт сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Сургалтаар орон нутгийн иргэдийн гамшгийн эрсдлийг бууруулах чадварыг бэхжүүлж, урьдчилсан мэдээ болон онцгой байдлын удирдлагын тогтолцоо, LEGS-ын аргачлалын талаарх мэдлэгийг нэмэгдүүлсэн. МҮХХ-ийн судлаач доктор Сувданцэцэг цаг уурын өөрчлөлт, цаг агаарын урьдчилсан мэдээний сэдвээр сургалтын материал бэлдэж Улаанбаатарт болсон сургагч багшийн сургалтанд танилцуулсан. Адилхан сургалтууд бусад 3 бүсэд болж өнгөрсөн. ОБЕГ-аас сургалтын ажилтан томилогдож бүсийн сургалт бүрт тусгай хөтөлбөр бэлдэж, хичээл заасан. Сургалтаар гамшгийг бууруулах төлөвлөгөө хэрэгжүүлэх, мал сүрэгт онцгой байдал тохиолдсон үед үнэлгээ хийх чиглэлээр онолын хичээл орсон.

Мерси Корпын аймгийн зохицуулагч нар орон нутгийн сургагч багш нартай хамт сургалтын хөтөлбөрийг тухайн сум орон нутгийн онцлогт тохируулан сайжруулж сургалтанд ашигласан. Сумын сургалтууд маш их амжилттай болж өнгөрсөн. Сургалтанд хамрагдсан иргэд LEGS-ийн аргачлал, сумын гамшгийн төлөвлөгөө боловсруулах, төлөвлөлтөнд олон нийтийн оролцооны ач холбогдлыг сайн ойлгосон.

Сургагч багшийн сургалтанд оролцогч бүрт LEGS-ын гарын авлага, “Зудын сургамж” ном, гамшгийн үеийн мэдээлэл бүхий нугалбарууд, УЦУОШГ болон МААЭУМТ төслийн зургууд, сургалтын бүх материал, видео хичээлүүдийг багц болгон олгосон. Сургалтын оролцогчдын ихэнх нь сургалтын материал, “Зудын Сургамж” номыг өндрөөр үнэлсэн. Жишээлбэл, Баянхонгор аймгийн Засаг дарга уг номыг уншаад өмнө нь хэвлэн тараасан ном нь бүх малчдад хүрэлцээгүй байгаа тул дахин 5000 ширхэгийг хэвлэж өгөөч гэсэн хүсэлт албан ёсоор тавьсан.

Үйл ажиллагаа 2.3 Сургагч багш бэлтгэх болон сумын сургалт

Сургагч багш бэлтгэх сургалт

2015 оны 9 сард LTS2 төсөл сургагч багш бэлтгэх сургалтыг 4 бүсэд зохион байгуулсан. Сургагч багш бэлтгэх 3 хоногийн сургалтанд нийт 164 сургагч багш хамрагдсан.

Хүснэгт 5: Сургагч багш бэлтгэх сургалт, байршил, оролцогчид хүйсээр

Огноо	Байршил	Хамрагдсан аймгууд	Сумын тоо	Оролцогчдын тоо		
				Нийт	Эм	Эр
9 сарын 2-4	Улаанбаатар	Сүхбаатар, Дундговь	5	17	9	8
9 сарын 9-11	Баянхонгор	Архангай, Баянхонгор, Өвөрхангай	23	51	19	32
9 сарын 14-16	Завхан	Завхан, Говь-Алтай	21	48	17	31
9 сарын 21-23	Увс	Баян-Өлгий, Ховд, Увс	20	48	19	29
Нийт			69	164	64	100



Фото 6: Сургагч багш бэлтгэх сургалт, Увс аймаг

Уг сургалтанд төслийн зорилтот 69 сум тус бүрээс 2 хүн оролцжээ. Нийт 178 хүн оролцсоноос 137 төрийн албан хаагч (Засаг даргын тамгын газар, багийн засаг дарга-77, Мал эмнэлэг үржлийн нэгжийн ажилтан-30, Онцгой байдлын алба хаагч-18, Цаг уур, байгаль орчны алба хаагч-11, Эрүүл мэндийн ажилтан-1), 32 ТББ-ын төлөөлөгч, 9 иргэдийн төлөөлөл тус тус хамрагджээ. Оролцсон хүний тоонд Мерси Корын ажилтнууд, ОБЕГ-ын төлөөлөгчид багтсан.

164 иргэн (үүнээс 64 эмэгтэй) сургалтанд амжилттай оролцоод сургагч багш болсон. Сургалтанд оролцогчдын мэдлэг ур чадвар

нь нэмэгдсэн. Сургалтын өмнөх болон дараах тестээр оролцогчдын мэдлэг 88,8%-иар сайжирсан гэсэн дүн гарсан. Үүнээс гадна 5-6 төрлийн шинэ ур чадвар эзэмшсэн: гамшгийн эрсдлийн үнэлгээ, мал сүргийн онцгой байдлын үнэлгээ явуулах, ажлын төлөвлөгөө гаргах, мал сүргийн үйл ажиллагаа сонгох, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах гэх мэт.

Оролцогчдын 95% нь сургалтын хөтөлбөр нь сургалтанд оролцогчдын ажил үүрэгтэй нягт уялдсан, 89,5% нь сургалтын зорилгоо биелүүлсэн гэж үнэлсэн.

Сумын сургалт

Орон нутгийн зөвлөхүүд Мерси Кортой хамтран “Гамшгийн аюулыг тооцъё, эртлэн төлөвлөө, эрсдэлгүй давъя” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа. Эхний сургалт 9 сард Баянхонгор аймагт явагдсан бол эцсийн сургалт нь 11 сарын 26-27-нд Баян-Өлгий аймгийн Алтай суманд зохион байгуулагдсан. Сум орон нутагт сургалт зохион байгуулахад сумын ЗДТГ сургалтын үйл ажиллагааг дэмжин бүх сумуудад өрөө танхимаар хангаж хамтран ажиллалаа.

2 хоногийн сургалтанд төрийн байгууллагын төлөөлөгчид, онцгой байдлын ажилтнууд, малчид, иргэд гээд нийт 1940 хүн хамрагдлаа. Үүнээс 1220 нь (63%) төрийн албан хаагч, 47 нь (2.4%) төрийн бус байгууллагын ажилтан, 673 нь (34.6%) малчид байсан. Нийт оролцогчдын 45.4% (880) нь эмэгтэй, 54.6% (1060) нь эрэгтэй байсан.

Хүснэгт 6: Сумын сургалт, байршил, оролцогчид хүйсээр

№	Аймаг	Сумын тоо	Оролцогчдын тоо		
			Нийт	Эм	Эр
1	Сүхбаатар	3	84	37	47
2	Дундговь	2	55	25	30
3	Архангай	6	160	92	68
4	Өвөрхангай	8	226	111	115
5	Баянхонгор	7	188	96	92
6	Завхан	15	445	206	239
7	Говь-Алтай	6	180	82	98
8	Ховд	3	97	41	56
9	Баян-Өлгий	5	150	49	101
10	Увс	12	355	141	214
Нийт		67	1 940	880	1 060

Сургалтын дараах тестээр сургалтанд оролцогчид мэдлэг чадвараа 41,2%-иар дээшлүүлсэн гэсэн дүгнэлт гарсан. Сургалтанд оролцогчид LEGS-ын стандарт, аргачлал, мал сүрэгт чиглэсэн үйл ажиллагаа, онцгой байдлыг үед авах арга хэмжээ, амьжиргааг хамгаалах болон бусад хэрэгцээтэй мэдлэг эзэмшсэн.

Ихэнх оролцогчид сургалтыг маш их таашаалтай хүлээж авсан. 1940 оролцогчдын 97.7% нь сургалтын зорилгоо биелүүлсэн; 88.9% нь сургалтын хөтөлбөрт сэтгэл хангалуун; 87.9% нь сургалтын хөтөлбөр нь оролцогчдын ажил үүрэгтэй нягт уялдсан гэж үнэлсэн.

Цаашлаад, сургалтанд оролцогчид өөрийн орон нутгийн гамшгийн төлөвлөгөөтэй танилцаж, түүнийг сайжруулахад LEGS-ын аргачлалыг ашиглаж эхэлсэн. Сумын гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөө нь урьдчилсан үнэлгээ хийгддэггүй, зөвхөн гамшиг тохиолдсон үед хэн юу хийх талаар төлөвлөсөн байдаг бөгөөд энэ нь учиртай дутагдалтай байгааг сургалтанд оролцогчид олж харж чадсан. Оролцогчдын (ялангуяа малчид, иргэдийн төлөөлөл) ихэнх нь сумын гамшгийн төлөвлөгөөг нууцын зэрэгт байдаг гэж ойлгодог, түүнтэй танилцаж байгаагүй, санал өгч үзээгүй байх жишээтэй.

Сургалтанд оролцогчид олж авсан мэдлэг чадвараа түгээн дэлгэрүүлэх, ашиглах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. 30% нь бусдад мэдлэг түгээнэ, 18,8% нь сурсан мэдсэнээ амьдрал ахуйдаа мөрдлөг болгоно, 25% нь сумын гамшгийн төлөвлөгөө сайжруулахад оролцоно, 12% нь өвөлжилтийн бэлтгэлээ сайн хангана гэж хариулжээ. Ялангуяа аймгийн онцгой байдлын газрынхан LEGS-ын сургалтыг ажилтнууддаа хийж өгөхийг хичээнгүйлэн хүссэн.

LTS2 төслийн үр нөлөө

LTS2 төсөл Сургагч багш бэлтгэх сургалт амжилттай зохион байгуулж 164 аймаг сумын сургагч багш бэлдсэн. Эдгээр 164 сургагч багш нь зорилгот 69 суманд 1940 хүнийг хамарсан сургалт

зохион байгуулсан. Сургалтанд оролцогчид LEGS-ын стандарт, аргачлал, мал сүрэгт чиглэсэн үйл ажиллагаа, онцгой байдлыг үед авах арга хэмжээ, амьжиргааг хамгаалах тухай мэдлэг эзэмшсэн.

Сургалтын үеэр нийт 35 сумын гамшгийн төлөвлөгөөнд хэсэгчилсэн өөрчлөлт оруулсан. Тухайн орон нутгийн онцлогт тохирсон гамшгийг тодорхойлж, түүнд тохирсон төлөвлөгөөний загварыг боловсруулсан. Жишээ нь, Хангайн бүсийнхэн голчлон зудын төлөвлөгөө, Зүүн болон Говийн бүсийнхэн ой хээрийн түймэр, Баруун бүсийнхэн мал амьтны гоц халдварт өвчин болон үер, Алтайн бүсийнхэн хүчтэй цасан болон шороон шуурга, ган зудын нөхцөл байдлуудыг авч үзэж төлөвлөгөөг өөрчилсөн.

- Хангайн бүс: 3 аймгийн 14 сумын гамшгийн төлөвлөгөөг сайжруулсан;
- Говийн бүс: 2 сумын төлөвлөгөөнд зуд нүүрлэх үеийн нүүлгэн шилжүүлэлт, тэжээлийн нөөцийн хувиарлалт хийх, дулаан хэвтэр бууцаар хангах ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг нэмж оруулсан;
- Зүүн бүс: түймрээс сэргийлэх, хамгаалах 1 сумын төлөвлөгөөг сайжруулсан;
- Баруун бүс: гоц халдварт өвчин, ган зудын нөхцөл байдлын урьдчилсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан. Нийтдээ 3 аймгийн 6 сумын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан;
- Алтайн бүс: Сумын гамшгийн төлөвлөгөө боловсруулах багт иргэд оролцож байгаагүй. Тиймээс ажлын хэсэгт иргэдийг оролцуулж нийтдээ 2 аймгийн 12 сумын төлөвлөгөөг сайжруулсан;

LTS2 төслийн баг 115 малчны туршлагаас 45 тэргүүн туршлага сонгож “Зудын сургамж” номонд оруулж, дахин хэвлэхээр боллоо. Энэ удаад “Зудын сургамж” номыг үндсээр нь өөрчлөн, онцгой байдлын үед малын тоо толгойг цөөрүүлэх, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, хашаа хороо дулаан хэвтэр бууцаар хангах, зуданд нэрвэгдсэн иргэдийг малжуулах зэрэг сэдвээр сайн туршлага сонгож, 9 бүлэгт хуваан оруулсан. Өнгөрсөн онд хэвлэгдсэн “Зудын сургамж” ном нь мачдын дунд маш их эрэлт хэрэгцээтэй байсан. Мерси Кор нэмж олон ширхэг ном хэвлэж зорилтот сумдын малчдад тараах төлөвлөгөөтэй байгаа.

Малын нэмнээ

Увс аймгийн Давст сумын дунд сургуулийн захирал Р. Бадамжав LTS2 төслийн сургалтанд сууж LEGS-ын аргачлалаар үнэлгээ хийх, гамшгийн төлөвлөгөө боловсруулахад олон нийтийн оролцоо чухал гэдгийг сайн ойлгож авчээ.

Үүний үндсэн дээр Бадамжав гуай зуданд өртөх магадлал өндөр малчдад туслах санаачлага гаргаж, 500 ш хөдөлгөөнт хашаа буюу нэмнээг хандивлахаа амлажээ. Тэрээр амлалтаа ажил хэрэг болгож төрийн байгууллагын ажилтнууд болон иргэдийн оролцоотойгоор 500 нэмнээ буюу хөдөлгөөнт хашаа хийж, Давст сумын Онцгой байдлын штаб-д 2015 оны 12 сарын 11- өдөр хүлээлгэн өгсөн байна.



4. БҮТЭЭМЖТЭЙ АГРИБИЗНЕСИЙН СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (PACS)

АНУ-ын Хөдөө аж ахуйн яам
2012 оны 9 сар – 2015 оны 9 сар


Төслийн зорилго

ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, боловсруулагч болон бусад бизнэс эрхлэгчдэд сургалт, техникийн туслалцаа үзүүлэх хүртээмжийг дээшлүүлэх, зах зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад ойртуулах замаар мах, махан бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүний өртгийн сүлжээний бүтээмжийг сайжруулж тэдгээр бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэх

Төслийн зорилтууд

- ХАА-н дэвшилтэт техник технологийн талаарх хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн мэдлэгийг сайжруулж, ХАА-н орц, фермерийн аж ахуйн менежментийн чанарыг дээшлүүлснээр мах, сүүн бүтээгдэхүүний салбар дахь үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх
- Үйлдвэрлэгчид мах, сүүн бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн стандартыг өргөнөөр хэрэглэж, үйлдвэрлэлийн дараах боловсруулалт, тээвэрлэлт, маркетингийг сайжруулснаар ХАА-н бүтээгдэхүүний худалдаа арилжааг нэмэгдүүлэх

Зураг 6. PACS төслийн аймгууд



Төслийн үр дүн

АНУ-ын Хөдөө аж ахуйн яам гэрээг батлав

2012 оны 9 сарын 14-нд Мерси Кор АНУ-ын Хөдөө аж ахуйн яамтай 2500 тонн ургамлын тос борлуулахаар гэрээнд гарын үсэг зурсан. Борлуулалтын орлогоор дараах зорилгонд хүрэх төсөл Монголд хэрэгжүүлэх байсан: 1) Хөдөө аж ахуйн дэвшилтэт техник технологийн талаарх үйлдвэрлэгчдийн мэдлэгийг сайжруулж, үйлдвэрлэлийн орц, фермерийн аж ахуйн менежментийн чанарыг дээшлүүлснээр мах, сүүн бүтээгдэхүүний салбар дахь үйлдвэрлэлийн хэмжээг

нэмэгдүүлэх 2) Үйлдвэрлэгчид мах, сүүн бүтээгдэхүүний чанар болон эрүүл ахуйн стандартыг өргөнөөр хэрэглэж, үйлдвэрлэлийн дараах боловсруулалт, тээвэрлэлт, маркетингийг сайжруулснаар хөдөө аж ахуйн худалдаа арилжааг нэмэгдүүлэх.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах процесс

2012-2015 оны хооронд Мерси Кор гадаад дотоодын зөвлөхүүдтэй хамтран бүтээгдэхүүнээ борлуулах төлөвлөгөө боловсруулж, АНУ-ын Хөдөө аж ахуйн ямаар батлуулах борлуулалтын бүх бичиг баримтыг бэлдэхэд анхаарлаа хандууллаа. Хүнсний аюулгүй байдлын тухай шинэ хууль гарч хувиргасан амьд организмтай хүнсний бүтээгдэхүүний импортыг хорьсоны улмаас Мерси Кор ургамлын тосны борлуулалтаа цуцлаад цагаан будааг сонгосон.

2014 онд Мерси Кор 2 удаа цагаан будааны тендер зохион байгуулсан ч, ирүүлсэн үнийн аль ч саналыг АНУ-ын Хөдөө аж ахуйн яам хүлээж аваагүй. Төслийн баг тендерт оролцогчидтой дахин уулзаж хоёр дахь худалдан авагчаас шинэ үнийн санал авсан. Мерси Кор шинэ үнийн саналыг 2015 оны 2 сарын 7-нд АНУ-ын Хөдөө аж ахуйн яаманд танилцуулж, 2015 оны 2 сарын 11-нд тус яамнаас татгалзсан хариу ирсэн. 2015 оны 9 сарын 17-нд АНУ-ын Хөдөө аж ахуйн яам төслийн үйл ажиллагааг хаах албан ёсны бичиг Мерси Корт илгээсэн.

5. ТӨРИЙН БА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН НЬ

Сайн засаглалыг дэмжих “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх идэвхитэй түншлэл ба иргэдийн оролцоо” (APPEAL), “Төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод тогтолцоон бэхжүүлэх”(ICOGS) зэрэг төслүүд 2015 онд дууссан хэдий ч, Мерси Корын ажилтнууд орон нутагт зохион байгуулагддаг олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагаанд уригдан оролцож, мэдлэг, мэдээлэл, туршлага, сургамжаа бусадтай хуваалцах, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх ажлуудыг хэрэгжүүлж байсан билээ.

2015 онд Мерси Корын ажилтнууд 13 аймагт дараах 7 төрлийн үйл ажиллагаанд түлхүү оролцсон: сургалт, уулзалт, хурал зөвлөгөөн, цуглаан, нээлттэй хаалганы өдөрлөгүүд, хэлэлцүүлэг, судалгаа. Нийт 148 үйл ажиллагаанд 5102 хүн хамрагджээ. Үүнд 2 675 эмэгтэй (52%), 1 629 (32%) төрийн албан хаагч, 630 (12%) ИНБ-ын төлөөлөл, 97 (2%) хэвлэл мэдээллийн ажилтнууд, 2 746 (54%) хувийн хэвшлийнхэн оролцсон байна.

Ихэнх арга хэмжээ нь анх Мерси Корын төсөл хөтөлбөрийн хүрээнд эхэлж байсан. Жишээ нь 141 буюу 95% нь Мерси Корын урьд өмнө нь хэрэгжүүлж байсан төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай шууд болон шууд бус хлбоотой. Одоо орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагууд эдгээр ажлыг санхүүжүүлж хэрэгжүүлдэг болсон билээ.

Хүснэгт 7: Үйл ажиллагааны тоо

No	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагааны тоо	Үр шим хүртэгчид буюу оролцогчдыг тоо	Эмэгтэй оролцогчдын тоо
1	Уулзалт	73	1453	647
2	Сургалт	32	932	527
3	Зөвлөгөө	14	75	39
4	Зөвлөгөөн	12	1 151	523
5	Судалгаа	3	701	486

6	Хэлэлцүүлэг	6	153	114
7	Цуглаан буюу нээлттэй хаалганы өдөрлөг	8	637	339
	Нийт	148	5 102	2 675

148-н үйл ажиллагааны 54 (37%) нь сайн засаглалыг дэмжих, 39 (27%) нь төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод, өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэх, 8 (5%) нь гамшгийн эрсдлийг бууруулах, 47 (31%) нь эдийн засгийн буюу өрхийн амьжиргааг дэмжих үйл ажиллагаа байсан юм.

График 1. Бусад үйл ажиллагаа



Төрөөс санхүүжүүлж байгаа ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд Ховд, Завхан, Өвөрхангай, Архангай, Говь-Алтай, Сүхбаатар зэрэг аймгийн бизнесийн сургалтанд хамрагдсан иргэдээс 122 иргэний бичсэн бизнес төлөвлөгөө батлагдаж, тус тусын аймгийнхаа Хөдөлмөрийн хэлтэсээс санхүүжилтээ авсан.

Мөн ICOGS төсөл дууссаны дараагаар Мерси Корын ажилтнууд 39 худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд орж ажилласан бөгөөд тус тендерүүд нь нээлттэй, ил тод зохион байгуулагдаж, шалгарсан компаниудтай ажлын гэрээ байгуулсан зэрэг олон сайхан үр дүн гарсан.

Бидний хэрэгжүүлж дууссан төсөл хөтөлбөрүүд цаашдаа ч иргэдийн амьдралд тогтвортой нөлөө үзүүлж байгаа гэдгийг бидний хамтын ажиллагаа нотолж байна. Манай хуучин төслүүд 2016 онд орон нутгийн төр, хувийн хэвшил, ТББ-ын хяналт, удирдлаган доор үргэлжлүүлэн хэрэгжинэ гэдэгт бид бүрэн итгэлтэй байна. Бид амжилтаа байгуулсан бизнесийн тоо, чадавхжуулсан эмэгтэйчүүдийн тоо, зохион байгуулсан сургалт, уулзалтын тоогоор хэмжвэл, Мерси Корын төсөл хөтөлбөрүүд үр дүнтэй, үр өгөөжтэй, тогтвортой бөгөөд Монголын иргэдийн амьдралд хамгийн их үр нөлөө үзүүлж чадсан гэж хэлж болно.

IV. Монгол улсын Засгийн газар, яам агентлагтай хамтран ажилласан нь

Мерси Кор байгууллага эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, нийгмийн амьдрал дахь оролцоог өргөжүүлэх зорилгод нэгдэж Монгол улсын бүх шатны төр захиргааны байгууллагуудтай түншилж хамтран ажиллаж байна:

Ерөнхийлөгчийн Тамгын газар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Мерси Кор Монгол байгууллага хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг хангах, сайн засаглалыг бэхжүүлэх, байгаль орчныг хамгаалах зэрэг Монгол улсын Засгийн газрын нэн тэргүүний хөгжлийн бодлогыг дэмжсэн тодорхой төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэхдээ дараахь яам, хэлтэс газруудтай шууд, бүтээлч харилцаа тогтоосонд их ач холбогдол өгч өндөр үнэлдэг билээ.

Сангийн яам

Төслийн санхүүжилт, зохицуулалтын газар (Зээл, тусламжийн бодлого болон зохицуулалтын хэлтэс)

Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Хүнс хөдөө аж ахуйн яам

Мал эмнэлэг, үржлийн газар

Хууль зүйн яам

Иргэний Харьялал, Шилжилт Хөдөлгөөний Ерөнхий газар Улсын бүртгэлийн ерөнхий газар

Хөдөлмөрийн яам

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төв

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам

Цаг уур, орчны шинжилгээний газар

Мерси Кор хөтөлбөр хэрэгжүүлэхдээ улсын болон орон нутгийн төрийн бус байгууллага, агентлагуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа уялдуулдаг. 2015 онд бидэнтэй хамтран ажилласан түнш байгууллагууд:

Засгийн газрын агентлагууд

Худалдан авах ажиллагааны газар, Онцгой байдлын ерөнхий газар, Зээлийн батлан даалтын сан, Барилгын хөгжлийн төв

Боловсрол, судалгаа

Монгол улсын Их сургууль

Төрийн бус байгууллагууд

Монголын үндэсний хөгжлийн хүрээлэн, Хөгжлийн шийдэл ТББ, Монголын төсөв боловсруулагчдын холбоо, Худалдан авалтын хөгжлийн төв, Монголын нутгийн удирдлагын

холбоо

Банкууд

ХАС банк, Төрийн Банк

Нийслэлийн газар, хэлтэсүүд

Баянзүрх дүүргийн татварын хэлтэс

Олон улсын байгууллага, төслүүд

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, АНУ-ын Гамшигт нэрвэгдсэн гадаад орнуудад тусламж үзүүлэх газар, АНУ-ын Хөдөө аж ахуйн яам, Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлаг, Азийн сан, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Японы Кейо Их сургууль

Аймаг, сум

Мерси Корын хөтөлбөрийн ажилтнууд аймаг, сумын төрийн албан тушаалтан, байгууллагатай хамтран төсөл хөтөлбөрүүдээ амжилттай хэрэгжүүлж ирсэн билээ. Бид дараахь аймаг, сумдын ЗДТГ, ИТХ, багийн засаг дарга, орон нутгийн ХАА алба, мэргэжлийн хяналтын алба, стандартчилал хэмжил зүйн алба, худалдаа аж үйлдвэрийн танхимын салбар, ажил олгогчдын эздийн холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага, татварын алба, газар, хэлтсүүдтэй үр дүнтэй ажиллаж ирсэн. Үүнд:

Хүснэгт 8: Хамтран ажиллаж буй аймаг сумдын жагсаалт

Архангай (8 сум) Булган, Өгийнуур, Төвшрүүлэх, Хашаат, Хотонт, Өлзийт, Эрдэнэбулган, Цэнхэр	Говь-Алтай (8 сум) Бугат, Баян-Уул, Дэлгэр, Халиун, Тонхил, Төгрөг, Шарга, Есөнбулаг,	Өвөрхангай (11 сум) Бат-Өлзий, Баян-Өндөр, Бүрд, Хархорин, Хужирт, Өлзийт, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Уянга, Арвайхээр
Баянхонгор (12 сум) Баянхонгор, Баянбулаг, Баян-Овоо, Бууцагаан, Галуут, Гурванбулаг, Жаргалант, Жинст, Заг, Өлзийт, Хүрээмарал, Эрдэнэцогт	Говьсүмбэр (2 сум) Сүмбэр, Шивээговь	Өмнөговь (3 сум) Даланзадгад, Баян-Овоо, Цогтцэций
Баян-Өлгий (6 сум) Алтай, Булган, Сагсай, Улаанхус, Цэнгэл, Өлгий	Ховд (7 сум) Алтай, Булган, Эрдэнэбүрэн, Ховд, Жаргалант, Мөнххайрхан, Үенч	Увс (15 сум) Баруунтүрүүн, Давст, Зүүнговь, Зүүнхангай, Малчин, Наранбулаг, Өндөрхангай, Сагил, Тэс, Түргэн, Хяргас, Цагаанхайрхан, Өмнөговь, Улаангом, Тариалан
Дорноговь (3 сум) Айраг, Сайншанд, Замын-Үүд	Сүхбаатар (6 сум) Асгат, Баруун-Урт, Дариганга, Эрдэнэцагаан, Мөнххаан, Сүхбаатар	Завхан (17 сум) Алдархаан, Асгат, Баянтэс, Баянхайрхан, Идэр, Их-Уул, Нөмрөг, Сонгино, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэлмэн, Тэс, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул,

		Эрдэнэхайрхан, Улиастай
Дундговь (4 сум) Адаацаг, Сайнцагаан, Эрдэнэдалай, Өлзийт		

V. Санхүүгийн Тайлан

Хүснэгт 9: Санхүүгийн хураангуй

Төслийн нэр	Хандивлагч байгууллага	2015 оны зардал (ам доллар)	Нийт төсөв (ам доллар)
ICOGS	ШХА	68 347	918 632
LGM	АНУ-ын ОУХА	539 819	1 869 852
LTS2	АНУ-ын ХААЯ	155 459	278 207
PACS	АНУ-ын ХААЯ	10 334	2 059 730
Нийт		773 959	5 126 421

Хавсралт 1: ТББ-уудын дэд тэтгэлэгт төслийн жагсаалт

	Байгууллага	Төслийн зорилго	Огноо
Архангай			
1.	Архангайн клуб	Худалдан авах ажиллагааны мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх олон нийтийн уулзалт зохион байгуулах; Эрдэнэбулган сумын худалдан авах ажиллагаа, тендерийн үр дүнг олон нийтэд сонингоор дамжуулан мэдээлэх	2013
2.	Шинэ залуу лидер	Хоёр зорилтот (Эрдэнэбулган болон Цэнхэр) сумын 3 худалдан авах гэрээн дээр худалдан авах ажиллагааны хяналт шинжилгээ хийх.	2013
3.	Мэдлэгийн сүлжээ	Төслийн зорилтот сумдын сонгогдсон тендерийн гэрээний гүйцэтгэлд мониторинг хийх, иргэдийн ойлголт, оролцоог нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааны тогтолцоог сайжруулах, бэхжүүлэх	2014
Баян-Өлгий			
4.	Хөшөөт Цэнгэл	Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжтэй хамтран Цэнгэл сумын иргэдэд сумын худалдан авах ажиллагааны үе шатын талаарх ойлголтыг сайжруулах зорилготой уулзалт ярилцлага зохион байгуулах	2013
5.	Ховд гол хамгаалах холбоо	4 зорилтот сумдын (Өлгий, Улаанхус, Цэнгэл болон Сагсай) 12 худалдан авах ажиллагаанд мониторинг үнэлгээ хийх	2013
6.	Үйлдвэрчний эвлэлийн холбоо	Иргэдийг худалдан авах ажиллагааны мэдээллээр ханган, чадавхижуулах замаар тэдэнтэй хамтран 2014 оны нийт худалдан авах ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гарган төрийн албан хаагчид, иргэдэд мэдээлэл хүргэх, гэрээний гүйцэтгэлд ИНБ-аас хяналт хийх дэвшилтэт арга, үйл ажиллагааг тодорхойлоход хувь нэмэр оруулах	2014
Баянхонгор			
7.	Олон нийтийн хөгжлийн төв	Баянхонгор болон Галуут сумдын худалдан авах ажиллагааны 4 гэрээнд хөндлөнгийн хяналт хийх	2013
8.	Олон нийтийн хөгжлийн төв	ИТХ-ын дэмжлэгтэйгээр гурван талт түншлэлийн зөвлөл байгуулах замаар орон нутгийн худалдан авах ажиллагааны явцад иргэдийн идэвх оролцоог сайжруулах	2014
9.	Сайн сайхан, хөгжлийн төлөөх залуу лидер эмэгтэйчүүд	Энэхүү төсөл нь орон нутгийн иргэдийн идэвх оролцоо, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн, худалдан авах ажиллагааны гэрээний гүйцэтгэлд ИНБ-уудын тавих хяналтыг нэмэгдүүлэх	2014
10.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо	Аймгийн төвд шинээр баригдсан барилга байгууламжуудад ХБИ-д хүртээмжтэй байх батлагдсан стандартын дагуу хийгдэж буй эсэх болон ХБИ-гэд зориулсан олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсвийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт хийх, үр дүнг ХБИ болон мэргэжлийн байгууллагууд болон олон нийтэд танилцуулах	2014

Дорноговь			
11.	Хөгжлийн төлөө Дорнын холбоо	Сайншанд сумын худалдан авах ажиллагааны явцуудад иргэдийн бүлэг байгуулах замаар мониторинг үнэлгээ хийн, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, иргэдийн уулзалт, сонин хэвлэлээр үр дүнгээ мэдээлэх тогтолцоог бий болгох	2013
12.	Өнөөгийн Дорноговь сонин	Худалдан авах ажиллагааны алба болон Гурван талт түншлэлийн зөвлөлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар орон нутгийн худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх.	2013
13.	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг Ажил олгогч эздийн Холбоо	Айраг сумын 6 худалдан авах ажиллагааны ажлын явц, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт хийх	2013
14.	Эмэгтэйчүүдийн зөвлөл	Орон нутгийн хөгжлийн сан, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, худалдан авах ажиллагаанд иргэдийн идэвхитэй оролцоог хангахад Сайн дурын идэвхитэн бэлтгэж, иргэд, орон нутгийн засаг захиргаа, ИТХ-тай хамтран ажиллах шинэлэг аргачлалыг тодорхойлох.	2014
15.	Манлайлагч иргэд	Худалдан авах ажиллагаан дахь иргэд, ИНБ-уудын хариуцлагатай оролцоог бэхжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын идэвхитэй хамтран ажиллагааг бий болгох.	2014
16.	Борхойн элч	Төрийн худалдан авах ажиллагааны ил тод, хариуцлагатай, үр ашигтай байдлын дээшлүүлэх үүднээс иргэдийн оролцоотой худалдан авах ажиллагааг суманд хэрэгжүүлэх ажлыг турших.	2014
17.	Хутагтын говийн наран	Орон нутаг дахь худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт байдал, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн чанарын судалгаа хийх замаар төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, тендерийн гүйцэтгэлийн хяналтанд иргэд, ИНБ-ын оролцоог тогтмолжуулахад нөлөөлөх	2014
Дундговь			
18.	Бямбаа багш сан	Аймгийн ИНБ-уудын сүлжээтэй хамтран худалдан авах ажиллагааны шинэ хууль тогтоомжуудыг иргэдэд сурталчлан таниулах, Сайнцагаан сумын худалдан авах ажиллагааны практикт иргэдийн хөндлөнгийн хяналтыг бий болгох	2013
19.	Малчдын Баянцагаан Холбоо	Сайнцагаан сумын 3 худалдан авах ажиллагааны тендерийн бичиг баримт, гэрээний гүйцэтгэлд хяналт тавих	2013
20.	ИНБ-уудын сүлжээ	Орон нутгийн иргэдийн худалдан авах ажиллагааны талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааны үе шатуудад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой.	2014

21.	Чулууны уулын аялгуу	Түншлэлийг хөгжүүлэх замаар орон нутгийн худалдан авах ажиллагааны явцад талуудын тавих хяналтыг сайжруулах	2014
22.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо	Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад шинээр баригдсан барилга байгууламжуудад ХБИ-д хүртээмжтэй байх батлагдсан стандартын дагуу хийгдэж буй эсэх болон ХБИргэдэд зориулсан олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсвийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт хийх, үр дүнг ХБИ болон мэргэжлийн байгууллагууд болон олон нийтэд танилцуулах	2014
Говь-Алтай			
23.	Биндэр Атас Богд	Худалдан авах ажиллагааны албатай хамтран худалдан авах ажиллагааны үе шатууд болон, ТҮХ-нд ИНБ-уудын төлөөллүүдийг идэвхтэй оролцуулах арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх	2013
24.	Үнэлэмж Алтай	Есөнбулаг сумын 2 худалдан авах ажиллагааны гэрээнд хяналт үнэлгээ хийх	2013
25.	Алтай Швейцарь сан	Төрийн худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын чадавхийг нэмэгдүүлж иргэний хяналтыг бий болгох замаар худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах	2014
26.	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын ГАА салбар	Төслийн зорилтот Баян-Уул, Шарга сумд 2014 онд ОНХС-ын хөрөнгөөр ОНО-той хийхээр төлөвлөсөн гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, гудамж тохижуулах, өвс тэжээлийн агуулах барих зэрэг худалдан авах ажиллагааны явцад иргэн, ИНБ-ын хөндлөнгийн хяналт, олон нийтийн оролцоог хэрхэн хангаж байгаад үнэлгээ хийж, нөлөөллийн ажлууд зохион байгуулах замаар худалдан авах ажиллагааны ил тод өрсөлдөөнт байдлыг нэмэгдүүлэх	2014
Говь-Сүмбэр			
27.	Олон нийтийн Оролцоотой Шийдэл	Баянтал, Шивээ-Говь, Сүмбэр сумдын дөрвөн худалдан авах ажиллагааны гэрээний гүйцэтгэлийг хяналт тавин, гарсан үр дүнгийн дагуу худалдан авах ажиллагааны нэгж болон ЗДТГ-т зөвлөмж хүргүүлэх	2013
28.	Олон нийтийн Оролцоотой Шийдэл	Сүмбэр болон Шивээговь сумын 2 худалдан авах гэрээний гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх.	2013
29.	Олон нийтийн Оролцоотой Шийдэл	Худалдан авах ажиллагааны мэдээллийн хүртээмжийг сайжруулах, ХАА-ны талаар иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах замаар гэрээний гүйцэтгэлд тавих иргэдийн хяналтыг дэмжих	2014
30.	Олон нийтийн Оролцоотой Шийдэл	Тендер сонгон шалгаруулах үйл явцад иргэдийн болон ИНБ-уудын үүрэг оролцоог сайжруулах	2014
Ховд			
31.	Ховдын толь	Худалдан авах ажиллагааны албатай хамтран худалдан авах ажиллагааны үе шатууд болон, ТҮХ-нд ИНБ-уудын төлөөллүүдийг идэвхтэй оролцуулах арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх	2013

32.	Сурах чадвар	Эрэлт ихтэй бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх бизнес эрхлэгчдэд хандсан захиалгат сургалтын сургалтын модуль боловсруулан мэргэжлийн түвшинд зохион байгуулах, тус худалдан авах ажиллагаанд оролцогч бизнес эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэн, худалдан авах ажиллагааг өрсөлдөөнт, ил тод нээлттэй болгох	2013
33.	Тунгалаг хөгжил	Жаргалант сумын 3 худалдан авах ажиллагааны гэрээнд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх.	2013
34.	Ногоон гарц	Жаргалант сумын 12 багт түншлэлийн салбар хороо байгуулан ТХ ны гишүүдийг чадавхижуулан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг, иргэдийн оролцоотойгоор шалгаруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хэрэгжилтэнд хяналт тавих бүхий л үйл ажиллагаанд идэвхитэй оролцон үр дүнг иргэдэд тайлагнан ажиллах тогтолцоог бүрдүүлэх	2014
35.	Ховдын толь	Худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцоог бодитой болгож, тендер шалгаруулалт болон гэрээний гүйцэтгэлд тавих хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох	2014
Өмнөговь			
36.	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний салбар	Өөрийн сайн туршлага дээр тулгуурлан Цогтцэций сумын түншлэгч талуудад Гурван талт түншлэлийн зөвлөлийн талаар сургалт зохион байгуулан, суманд ЗТТЗ байгуулах	2013
37.	Говийн Хөгжлийн Зуун	Худалдан авах ажиллагааны албатай хамтран Даланзадгад сумын худалдан авах ажиллагаанд оролцогч талуудад зориулан тогтмол мэдээллээр хангах, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах	2013
38.	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний салбар	Даланзадгад, Баян-Овоо сумдын 4 худалдан авах ажиллагааны гэрээний гүцэтгэлд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх.	2013
39.	Баян тост	Даланзадгад сумын худалдан авах ажиллагааны гэрээ болон гүйцэтгэлийн талаарх мэдээллийг хүртээмжтэй болгон, ИНБ-ууд хөндлөнгийн хяналт хийх загвар боловсруулан, хэрэгжүүлж, гэрээний гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавих	2014
40.	Монголын баг сумдын холбоо	Гурван талт түншлэлийн зөвлөл, ИТХ-аар дамжуулан худалдан авах ажиллагаан дахь иргэдийн оролцоо, ил тод өрсөлдөөнт байдлыг нэмэгдүүлэх	2014
41.	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний салбар	Оролцооны аргад тулгуурласан хяналт үнэлгээ хийх замаар найман худалдан авах гэрээнд ИНБ-ын хөндлөнгийн хяналт тавих	2014
Өвөрхангай			
42.	Энх түмний хүч	Худалдан авах ажиллагаа болон үнэлгээний хороонд ажиллах ТББ-ыг сонгох жишиг журмыг гаргах, зөв тогтолцоог бий болгох	2013

43.	Оюунлаг Иргэн — ЛЭОС	Орон нутгийн төрийн албан хаагчид, Худалдан авах ажиллагааны нэгжийн ажилтнуудад худалдан авах үйл ажиллагааны шинэ бодлого журмын талаар хэлэлцүүлэг зохион байгуулах, худалдан авах ажиллагааны үйл явц, хариуцлагын талаар олон нийтийн уулзалт мэдээлэл зохион байгуулах.	2013
44.	Сарлаг Эрдэнэ холбоо	Орон нутагт төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр төрийн ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар зохион байгуулах	2013
45.	Хэрэглэгчдийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэг	Арвайхээр сумын хүүхдийн цэцэрлэг болон цахилгааны дэд станц барих ажлын гэрээний гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт хийж, үр дүнг олон нийтэд мэдээллийн хэрэгсүүдээр мэдээлэх	2013
46.	Либераль Эмэгтэйчүүдийн Оюуны Сан	Арвайхээр болон Уянга сумын 3 худалдан авах ажиллагаанд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх	2013
47.	Хэрэглэгчдийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэг	Иргэний хяналтын журмыг ИНБ-ууд, Худалдан авах ажиллагааны албаны оролцоотойгоор сайжруулан аймгийн хэмжээнд дагаж мөрдөх журмыг боловсруулан гаргаж, ИТХ-аар баталгаажуулах замаар тендерийн бүх үе шатанд тавих иргэний хяналтын үйл ажиллагааг тогтворжуулах	2014
48.	Хүчирхэг үндэстэн	Худалдан авах ажиллагааны мэдээллийг цаг тухайд нь оролцогч талуудад вэб сайт хэлбэрээр хүргэх, мэдээллийн эргэх холбоо, ил тод, тогтвортой байдлыг сайжруулах	2014
49.	Энх түмний хүч	Орон нутагт шинээр баригдсан болон засвар хийгдсэн барилга, замын бүтээн байгуулалтын ажлууд нь ХБИ-д хүртээмжтэй байх батлагдсан стандартын дагуу хийгдэж буй эсэх дээр хөндлөнгийн хяналт хийх замаар ХБИ-ийн идэвхижүүлэх, чадавхижуулах, ХАА-нд оролцох оролцоог сайжруулах	2014
50.	ЛЭОС	Орон нутагт чадавхитай иргэний хяналтын бүлэг бий болгож, 2014 оны хөрөнгө оруулалтын үйл явцад хамтран хяналт үнэлгээ хийх замаар худалдан авах ажиллагааны хариуцлагыг нэмэгдүүлэх	2014
51.	Иргэний санаачлага Орон нутгийн хөгжил	Төрийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл дэхь иргэд, олон нийтийн хяналтын тогтвортой байдлыг хангах	2014
Увс			
52.	Сайн тус	Төрийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гэрээний гүйцэтгэлд иргэд олон нийтийн бодит оролцоог хангахад Улаангом сумын ИТХ-тай хамтран ажиллаж, “Иргэдийн оролцооны оновчтой шинэлэг загвар сүлжээ”-г бий болгож сайн туршлага нэвтрүүлэх	2014
53.	Өсвөр үе-ирээдүй төв	Сумуудын худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт байдлыг үнэлэх шинэ журам боловсруулж аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх замаар сумуудын худалдан авах ажиллагааны үйл явц дахь	2014

		хариуцлагыг нэмэгдүүлэх	
Сүхбаатар			
54.	Ажил олгогч эздийн холбоо	Зорилтот 3 суманд (Баруун-Урт, Мөнххаан, Сүхбаатар) зарлагдсан тендерийн баримт бичгүүдэд хөндөнгийн хяналт хийх	2013
55.	Албан журмын даатгагчдын холбоо	Худалдан авах ажиллагааг зохион байгуулагч талуудыг чадавхижуулах, иргэдийн оролцоотой хөндлөнгийн үнэлгээг гэрээний гүйцэтгэл дээр хийлгэх замаар худалдан авах ажиллагааны чанар, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах	2014
56.	Монголын үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын холбооны аймгийн салбар зөвлөл	Зорилгод 3 суманд орон нутгийн худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт байдлыг бэхжүүлэх, төслийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн нөлөөллийн ажлуудыг гүйцэтгэж, худалдан авах ажиллагаанд хөндлөнгийн хяналт, шалгалт тогтмол хийх эрх зүйн орчинг бүрдүүлэх	2014
Завхан			
57.	ЗА Багана	Барилга, хүнс, зам гүүрийн засварын чиглэлээр гурван гэрээний гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийж, гүйцэтгэлийн талаар тайлагнах	2013
58.	Өрнөх хөгжил	Улиастай сумын ИНБ-уудын сүлжээ болон ИТХ-ын төлөөлөгчдөд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, түүнд иргэдийн оролцооны чиг үүргийн талаар сургалт зохион байгуулах	2013
59.	Баруун бүсийн Банк санхүүгийн байгууллагын ажилтны хөгжлийг дэмжих төв	Улиастай суманд хийгдсэн 3 худалдан авах ажиллагааны гэрээний гүйцэтгэлт хяналт үнэлгээ хийх	2013
60.	Энхийн төлөө хамтдаа	Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул сумдад 3 талт түншлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2014
61.	Туна Тэргэл сан	Улиастай суманд ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Төрийн худалдан авах ажиллагааны явц гүйцэтгэлд ИНБ, иргэдийн бүлгээс хөндлөнгийн хяналт тавих арга зүйг орон нутагт нутагшуулахад хувь нэмрээ оруулах	2014